



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	2
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	4

***Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх/-ны 05 дугаар сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Хянан шалгах түр хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 5 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 55 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Тэгшжаргал, Р.Дүүрэнбаяр мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн тавьсан асуултад Түр хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Түр хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хаалттай хэлэлцэх асуудлын дараалалд “Нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол даргалагчийг томилох тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Түр хорооны тогтоолын төслүүдийг нэмж оруулья гэсэн горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 2  
Бүгд: 4  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 1  
Бүгд: 4  
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Хаалттай хэлэлцэх асуудлын дараалалд хоёр асуудал нэмж оруулж, хэлэлцье гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 1  
Бүгд: 4

75.0 хувийн саналаар дэмжигдсэн тул хаалттай хэлэлцэх асуудлын дараалалд хоёр асуудал нэмж оруулж, хэлэлцэхээр тогтов.

Түр хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Хянан шалгах түр хорооны дотоод асуудлыг хэлэлцэх учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 1  
Бүгд: 4

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 14 цаг 07 минутад хаалттай горимд шилжүүлэв.

*Нээлттэй хуралдаан 12 минут үргэлжилж, 5 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр 14 цаг 07 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ  
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим 13 цаг  
55 минут.

### ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Цэрэнпунцаг:** Эрхэм  
гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье ээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор байгуулагдсан ашигт малтмал, хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Доржханд гишүүн орж ирсэн үү? Ирээгүй.

Тэгвэл өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны гишүүн Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны гишүүн Адъяа, Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны гишүүн Б.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны гишүүн Цэрэнпунцаг нар ирж, ирц 80 хувьтай бүрдсэн тул өнөөдрийн хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Ингээд хэлэлцэх асуудлаа та бүхэндээ танилцуулъя.

Нэгдүгээрт, Хянан шалгах түр хорооны сонсголыг товлон зарлах тухай тогтоолын төсөл,

Хоёрдугаарт, Нотлох баримтыг шинжлэн судлах, Сонсгол даргалагчийг томилох тухай тогтоолын төсөл,

Гуравт, Нотлох баримтыг шинжлэн судлах, дараалал тогтоох тухай тогтоолын төсөл,

Дөрөв, Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай тогтоолын төсөл,

Тав, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай тогтоолын төсөл.

Хянан шалгах түр хорооноос 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр баталсан нотлох баримт гаргуулах тухай 06 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах асуудлууд байгаа.

Хэлэлцэх асуудлын 2 болон 5 дугаар асуудал нь хэлэлцэх асуудлын тов дараалалд байхгүй боловч хяналт, шалгалтын ажлын шаардлагаар өнөөдрийн хэлэлцэх асуудалд нэмж оруулах горимын санал гаргаж байна. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Хоёр дахь нь нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол даргалагчийг томилох тухай тогтоолын төсөл, 5 дахь нь тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай тогтоолын төсөл гэсэн энэ 2 асуудал шинээр орж ирж байгаа.

Эхний 2 дахь асуудал болох. Танилцуулахгүй юм уу горимын санал дээрээ? Тэгээд энэ 2 асуудлыг оруулъя гэдэг дээр санал хураалт явуулъя.

Адъяа гишүүн саналаа хэлье.

**Ш.Адьяа:** Түр хорооны гишүүдийнхээ амгаланг айлтгая.

Заавал энэ хаалттай хэлэлцэнэ гэдэг нь ямар үндэслэлээр хаалттай хэлэлцэх гээд байгаа юм. Нээлттэй явж байгаа биз дээ тэ? Хаалттай хэлэлцэх шаардлагагүй юу байгаа юм гэсэн асуулт асууя.

Яагаад хаалттай хэлэлцэх гэж байгаа юм. Энэ чинь нууц юм алга байна шүү дээ. Одоо энэ чинь нэг түрүүчийнхээ түр хороог хаалттай гээд л ингээд л, авчраад л тулгаад л маргааш нь тийм юмыг бид хийхгүй гэж ярьсан шүү дээ Эрдэнэсамбуу. Тэгээд л яг мэдээллээ хамгийн гол нь нээлттэй тэр хүмүүст урьдчилж хүргэе.

Дээр нь хаалттай гэдэг юмыг больё л гэдэг ийм л зарчмыг би яриад яваад байгаа шүү дээ. Энэ нуух юм бол байхгүй шүү дээ. Хаалттай болохоор л наадах чинь ингээд том хуйвалдаан болно гэж үзнэ. Иргэд одоо энэ чинь хамгийн сүүлчийн Түр хороо тэгээд сүүлд нь энэ ашигт малтмал энэ маш том бүлэглэл энд ирээд явж байна лээ шүү дээ. Хэвлэл мэдээллээр янз бүрийн турхиралт хийгээд харж байгаа шүү дээ та нар.

Дээр нь тэр Мон Энкогийн нэг хачин нөхөр инженер гээд Занданшатар даргын үүдэн дээр өчигдөржин тэр Төмөртөмөө гээд нөхөртэй ирж лобби хийгээд сууж байсан. Ийм байж болохгүй. Энийг зүгээр нээлттэй л явах ийм саналтай байна. Юуг нь нуух юм. Өнөөдөр энд хаалттай хийлээ гэвэл энд Түр хорооныхон авч ирээд л баахан юмыг нь дарж байна. Нууц юм яаж байна мөн ийм л юм болно шүү дээ. Ер нь нээлттэй л явъя. Би бол тийм бодолтой байна. Энэ хаалттай

саналыг би дэмжихгүй байгааг хэлж байгаа шүү горимын саналыг нь.

**Ц.Цэрэнпунцаг:** Энэ 2 асуудлыг оруулъя гэдэг дээр санал хураалт явуулъя.

2 болон 5 дугаар асуудлыг хэлэлцэх асуудалд оруулъя гэсэн томъёоллоороо санал хураалт.

Адьяа гишүүн таны төхөөрөмж ажиллаж байгаа биз дээ. Та горимын санал гаргачих, горимын санал гаргачих. Адьяа гишүүний микрофон.

**Ш.Адьяа:** Сая энэ миний төхөөрөмж ажиллахгүй л болчихлоо доо. Би уг нь дэмжиж санал өгч байгаа юм. Дахиад санал хураалгах уу? Миний энэ саналыг хүчингүй болгох.

**Ц.Цэрэнпунцаг:** Адьяа гишүүн саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргасан тул, энэ санал хураалтыг явуулъя аа. Саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэж гишүүд 75 хувь нь дэмжсэн тул саяын хураасан санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд дахин санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүдийн 75 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Нэмэх

*саналтай гишүүн байхгүй байна.  
Хэлэлцэх асуудалдаа оръё оо.*

*Ингээд хэлэлцэх асуудлууд нь Түр хорооны дотоод асуудал учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасныг үндэслэн хаалттай хуралдах горимын санал гаргаж байна аа.*

*Хаалттай горимоор хэлэлцье гэдэг горимын санал гаргаж байна. Санал хураалт явуулъя.*

*Санал хураалт.*

*Гишүүдийн 75 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.*

*Хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя.*

*14.07 цаг*

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ  
П.МЯДАГМАА